



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 54

Номгон

“Хонгор шинэ агро” орон нутгийн өмчит
аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын
дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 123 дугаар тогтоолоор баталсан “Хонгор шинэ агро орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм”-д дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. Дүрмийн 3.1.”а”-г “Аймгийн хэмжээний хэрэгцээт байгалийн хадлан бэлтгэх, аюулгүй нөөцийг бүрдүүлж, хадгалж хамгаалах, малын тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, газар тариалан эрхлэгчдийг дэмжиж хамтарч ажиллах” гэж найруулах

1.2. Дүрмийн 7.4.4. Удирдах зөвлөл, Онцгой комиссын шийдвэрээр олгосон өвс тэжээлийн үнийн зөрүү, алдагдлыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр оруулж шийдвэрлүүлнэ” гэж нэмэх

1.3. Дүрмийн 8.13 “Онцгой комиссын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид өвсний үнийг бууруулах асуудлыг шийдвэрлэнэ” гэж нэмэх

1.4. Дүрмийн 15.2. Тухайн газарт ажиллагсадыг төрийн үйлчилгээний албан хаагчидтай адилтган үзэж, удаан жилийн нэмэгдэл, тэтгэмж, нөхөн олговрыг үйлдвэрийн газар дотооддоо шийдвэрлэнэ” гэж нэмэх

2. Тогтоол, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

ЦОТГОНБАЯР

1190061

D:/2018/Alban bichig/th togtool-2019